



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 04

Мандалговь

“Дундговио ногооруулья” дэд хөтөлбөр
батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар 18.1.2 з, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Дундговио ногооруулья” дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Хоёр. “Дундговио ногооруулья” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хандив, тусламж, төсөл хөтөлбөрт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.


Гурав. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2021 оны 08 дугаар сарын 06-ны
өдрийн 07 дугаар тогтоолын хавсралт



“ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ”
2021-2024 оны дэд хөтөлбөр

МАНДАЛГОВЬ

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ. “ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ” ДЭД ХӨТӨЛБӨР

ДӨРӨВ. ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР, САНХҮҮЖИЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УТ - УЛСЫН ТӨСӨВ

ОНТ – ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

АЗДТГ – АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХОХБТХ – ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТЭС

ХХААГ- ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

БОАЖГ- БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

ГХБХБГ- ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

БСУГ – БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР

ОНӨҮГ – ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

ХТГ – ХОТ ТОХИЖУУЛАХ ГАЗАР

ОЖД – ОЛОН ЖИЛИЙН ДУНДАЖ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Аймгийн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн өнөөгийн байдал, нөлөөлж байгаа хүчин зүйлс

Тус аймаг газар зүйн байршил, уур амьсгалын нөхцөл, газар нутгийн гадаргын хэв шинж, экологийн тогтолцооны хувьд нэн эмзэг, хуурай тал хээр, цөлөрхөг хээрийн бүсэд оршдог бөгөөд 7469.0 мян.га нутаг дэвсгэртэй. Үүнээс 7146.53 мян.га буюу 95.3% нь бэлчээр, 21.12 мян.га буюу 0.29% нь төв суурингийн газар болно. Улсын тусгай хамгаалалттай 4 газар нийт 426.41 мян.га, аймгийн тусгай хамгаалалттай 18 газар нийт 171.45 мян.га талбай байна.

Дэлхийн хүн амын өсөлт, үйлдвэржилт, ХАА-н үйлдвэрлэл, хотжилт, ус болон цахилгаан эрчим хүчний замбараагүй хэрэглээнээс үүдэн мөнх цас, мөсөн голууд хайлах, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэх, ундны усны гачигдал үүсэх зэрэг уур амьсгалын өөрчлөлтүүд ихээр гарах болсон нь дэлхий нийтийн анхаарлыг татах болоод байгаа билээ. Дэлхийн дулаарал нь газрын гадарга дээр +1.98-+2⁰С, Монгол улсад +2.2⁰С, Дундговь аймагт +1.4-+4.5⁰С-ээр / 1991-2020 он ОЖД / нэмэгдэж байгааг эрдэмтэд судлан тогтоосон.

Европт халуун зунаар цас орох, Африкт цасан шуурга дэгдэх, Азид хүчтэй цунами, далайн шуурга болох гэх мэт гамшигт үзэгдэл ихээр гарах болсон. /ЗХАБНЗЗХолбоо 8 дугаар бүгд хурал/

Монгол улсын нийт бэлчээрийн 90 орчим хувь нь цөлжилт, газрын доройтлын үйл явцад өртөх магадлалтай нутагт хамрагдах бөгөөд цөлжилтийн аюулын зэрэглэл нэмэгдэж, өнөөгийн байдлаар нийт нутаг дэвсгэрийн 72 хувь хүртэл өргөжсөн. Эдгээрээс үнэлгээ, зураглалын өнөөгийн үр дүнгээр цөлжилт нь:

- Нэн хүчтэй 5%
- Хүчтэй 18%
- Дунд зэрэг 26%
- Сул 23% байна.

Дундговь аймаг хүчтэй зэрэглэлд хамрагдах болжээ. /НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенц/

Сүүлийн жилүүдэд хур тунадасны хэмжээ багасахын зэрэгцээ хурц нартай өдрийн давтамж, тоо ихэссэнээр гандах болсон. Мөн салхины дундаж хурд нэмэгдэж 12 м/сек-ээс дээш шороон шуургатай өдрийн тоо ихэссэн. Гамшигийн хэмжээнд хүрсэн үзэгдлүүд ч байн байн гарах болов. Сүүлийн 5 жилийн агаарын дундаж температур Эрдэнэдалай, Адаацаг, Говь-Угтаал сумдын нутгаар 1.9-2.3 градус, Мандалговь, Сайхан-Овоо, Дэрэн сумдын

нутгаар 3.1-3.4 градус бусад нутгаар 4.4-4.7 градус дулаан байсан нь олон жилийн дунджаас / 1991-2020 он / 0.1-0.5 градус дулаан байсан байна.

2016 онд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ 103,9-243,9 мм, 2017 онд 59,1-156,7 мм, 2018 онд 141,5-212,2 мм, 2019 онд 44,1-163,5 мм, 2020 онд 37,5-159,1 мм, мм тунадас орсон нь ОЖД-тай харьцуулахад 2016, 2018 онд дунджаас ахиу, 2017, 2019, 2020 онд ОЖД-аас 2 дахин бага хур тунадас орсон байна. Говийн бүс нутагт хур бороо багасаж, хэт халснаас хөрсний доройтол хүчтэй явагдаж, ургамлын төрөл зүйл багасаж цөлжилт үүсэх шалтгаан болж байгаа.

Дундговь аймагт 2011-2020 оны сүүлийн 10 жилийн бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын 8 дугаар сарын ургацын мэдээнээс харахад жилд дунджаар 1,0 – 4,3 ц/га ургац гарсан байна. Энэ нь хур тунадаснаас хамаарч жил жилд харилцан адилгүй ургац гарсан. Тухайлбал хамгийн их ургац 2011 онд Цагаандэлгэр сумын Дэлгэрэх зам баг, Номт зогсоол цэгт 12,2 ц/га, 2012 онд Сайхан-Овоо сумын Онги багийн Яралзах зогсоол цэгт 12,1 ц/га ургац авсан. 2016 онд Дэрэн сумын Алаг өндөр багийн Могойт зогсоол цэгт 11,2 ц/га ургац авчээ. 2011 оны 8 дугаар сарын ургацын хэмжээ ойрын жилүүдээс элбэг байсан ч зуны дээд ургац аймгийн ихэнх нутагт буурсан. Ялангуяа сүүлийн 2017-2020 оны ургац 1,8-3,3 ц/га болж маш их буурсан. Энэ нь 70, 80-аад оны үеийнхээс 10 дахин түүнээс бага байсан.

2019-2020 оны байдлаар ургамлын төрөл зүйл эрс цөөрч хөл газрын ургамал түрж ургах нь элбэг болсон

Шороон шуурганы давтагдал жилээс жилд нэмэгдэж 2016 онд 106 удаа, 2017 онд 188 удаа 2018 онд хамгийн олон буюу 315 удаа 2019 онд 177 удаа 2020 онд 284 удаа ажиглагдсан. Хөрсний өнгөн хэсгийн 1 см хүртэл үеийн нунтаг шороон хэсэг хүчтэй салхины нөлөөгөөр хийсч улмаар сайр чулуу болон бүдүүн ширхэгтэй элс бүхий гадаргатай болсон. Тус аймгийн нутагт 15 м/с-ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо 3 дахин, нөөлөг салхитай өдрийн тоо 4 дахин өссөн нь цөлжилт элсний нүүдэл, шороон шуурга ихсэх нэг үндсэн шалтгаан юм

Малын тоо, бүтэц, зарим нутагт бэлчээрийн даац бууруулах, хөрсний талхлалтыг нэмэгдүүлэх нэг нөхцөл болж байв. Орох хур тунадасны хэмжээ багасаж, ургамлын гарц муудахын хэрээр бороо орсон газар нутагт ургаж гүйцээгүй байхад шавж идээд тарж, ахиад ургах нөхцөлийг муутгах нь хэвийн үзэгдэл болсон. Бэлчээрийн усан хангамжаас шалтгаалж 1 худгаас олон мал ууж, талхлалтыг үүсгэдэг. Аймгийн хэмжээний нийт бэлчээрийн усан хангамж 50,3 хувьтай байна.

Үүний зэрэгцээ малын тоо толгойг хөөцөлдөж сүргийн бүтцэд гарсан өөрчлөлтийн улмаас ямааны тоо жилээс жилд өсч нийт сүргийн 45%-ийг эзлэх болсон нь бэлчээр нутгийг зүй зохистой ашиглах нэг гол шалтгаан болж байгаа юм.

Уур амьсгалын дулааралт, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны доройтол цөлжилт цаашид энэ хурдцаар үргэлжилбэл орон нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжил, хүн амын эрүүл мэнд, амьжиргаанд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх магадлал улам бүр нэмэгдэх болно.

1.2. “Дундговно ногооруулья” дэд хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл шаардлага

“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2021-2050), “Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр (2005-2035), “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр” (2019-2023) зэрэг олон улсын хийгээд үндэсний түвшний бодлого, хөтөлбөрүүд, “Дундговь аймгийн Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл (2021-2025), аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр эдгээрт байгаль орчны талаар тусгагдсан холбогдох заалтыг хэрэгжүүлэх үүднээс “Дундговно ногооруулья” дэд хөтөлбөрийг боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

ХОЁР. ЗОРИЛГО

Цөлжилт, газрын доройтол, элсний нүүдэл шороон шуурганы сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлж, хүнсний ногоо тариалагч иргэн, аж ахуйн нэгж, хоршоодын үйл ажиллагааг эрчимжүүлэн, иргэдийг эрүүл хүнсээр хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

ГУРАВ. “ДУНДГОВИО НОГООРУУЛЬЯ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

3.1 Аймгийн хэмжээнд ойн зурвас, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх.

3.2 Аймгийн хүн амыг эрүүл хүнсээр хангах, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хүлэмж, газар тариалан эрхлэлтийн цар хэмжээг нэмэгдүүлэх.

3.3 Бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага хувийн хэвшил, иргэдийн экологийн боловсролыг системтэй дээшлүүлэх.

Хөтөлбөр нэг үе шаттай (2021 – 2024 он)

Зорилт: 3.1

Ногоон байгууламжийн талбайн хэмжээ 2020 онд 369.4 га-д 221640 мод, сөөг, 390 м² цэцгийн мандал байсныг 2024 онд 833 га-д 500,000 мод, сөөг, 700 м² талбай зүлэгжүүлж, 900 м² талбайд цэцгийн мандал тарьж ургалтыг 85 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

3.1.1 Тухайн жилийн сумдын ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламж хийх газрын байршил, талбайн хэмжээг тусган батлуулах.

3.1.2 Сайнцагаан сум 100,000 мод, сөөг бусад 14 сум 12,740 мод тарих.

3.1.3 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх.

3.1.4 Говийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгацын нэр төрлийг нэмэгдүүлэн байгууллага, ААН, сум, иргэдийн хэрэгцээг хангах.

3.1.5 Заган ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах.

3.1.6 Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 20 га-д хийлгэх.

3.1.7 Мод тарьж ургуулсан сум, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийг шалгаруулж урамшуулах, уралдаан зохион байгуулах.

3.1.8. Цэвэрлэх байгууламжийн саарал усыг мод усалгааны системд ашиглах, шинэ техник технологийг нэвтрүүлж, усыг хэмнэлттэй, үр ашигтайгаар ашиглах.

3.1.9 Цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн зам талбай, байгууллага аж ахуйн нэгжийн гадаад орчны талбайд мод, цэцэг тарьж, зүлэгжүүлэх.

Зорилт: 3.2

Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйн эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоодын үйл ажиллагааг дэмжих замаар тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэн 2020 онд аймгийн хүнсний ногооны хэрэгцээний хангалт 17,2 хувь байсныг 2024 онд 40 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

3.2.1 Сумдад иргэдийн бүлгийг түшиглэн зуны хүлэмжийн аж ахуйг дэмжих, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах.

3.2.2 Хүнсний ногооны технологийн ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үр, бордоо, гар багаж, усалгааны болон хүлэмжийн тоног төхөөрөмж нийлүүлүүлдэг аж ахуйн нэгжтэй тариаланчдыг холбож зуучлах, дэмжих.

3.2.3 Сайнцагаан суманд байгуулагдсан "Өвлийн нарлаг хүлэмж"-ийг түшиглэн хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулах.

3.2.4 Нутгийн хөрсөнд тарьсан төмс хүнсний ногоо, жимс жимсгэнийн бизнес эрхлэгчдийг дэмжих төвийн борлуулалтын цэгээр дамжуулан зах зээлд нэвтрүүлэн бүтээгдэхүүнийг нь сурталчлах, нэрийн бүтээгдэхүүн бий болгох.

3.2.5 Бэлчээрт олон наст ургамал цацах, тариалах, өнжөөж сэлгэж нөхөн сэргээх, тарималжуулах.

Зорилт: 3.3

Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 400-аас доошгүй иргэнийг дадлагажуулж, чадавхжуулах.

Арга хэмжээ:

3.3.1 Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, хүнсний ногоон, жимс жимсгэнийн тариалагч иргэд, үйлдвэрлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах.

3.3.2 Байгальд ээлтэй цэцэрлэг, сургууль, эко клубын үйл ажиллагааг эрчимжүүлж чуулга уулзалт зохион байгуулж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах.

3.3.3 Байгаль орчныг хамгаалах, цөлжилтийг сааруулах талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн мэдээллийн сүлжээгээр сурталчилгаа хийх.

ДӨРӨВ. ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР, САНХҮҮЖИЛТ

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

4.1.1 Улсын төсөв;

4.1.2 Орон нутгийн төсөв;

4.1.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө, хандив;

4.1.4 Урт хугацааны зээл, тусламж;

4.1.5 Олон улсын байгууллагын хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгө;

ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ

**“ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ” ХӨТӨЛБӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН**

2021.08.06

Мандалговь хот

Бүтэц	№	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Төлөвлөсөн онд хүрэх түвшин			Зорилт оны түвшин 2024 он	Санхүүгийн эх үүсвэр, хэмжээ /мян.төг/	Хариуцах эзэн
						2021	2022	2023			
Арга хэмжээ	1.1	Тухай жилийн сумдын ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламж хийх газрын байршил, талбайн хэмжээг тусган батлуулах	Батлагдсан эсэх	Тийм-1 Үгүй-0	1	1	1	1	1	-	ГХБХБГ Сумдын ЗДТГ
	1.2	Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Тарьсан модны тоо	Тоо	101975	146270	216270	289702	363735	УТ, ОНТ, Хувийн хэвшил 49163.0	БОАЖГ сумдын ЗДТГ ХТГ СДОА
	1.3	Говийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгацаар байгууллага,	Тарьц, суулгацын тоо	Тоо	13878	30428	50428	75428	100428	ОНТ 259650.0	СДОА

		ААН, сум, иргэдийн хэрэгцээг хангана.									
1.4	Цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн зам талбай, байгууллага аж ахуйн нэгжийн гадаад орчны талбайд мод болон цэцэг тарьж, зүлэгжүүлэх.	Модны тоо	Тоо	119665	120265	126265	131265	136265	ОНТ, Хувийн хэвшил 350352.6	ХТГ ААН	
		Зүлэгжүүлсэн талбай	м ²	-	-	200	600	700			
		Цэцгийн мандал	м ²	390	390	560	730	900			
1.5	Заган ойн менежментийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах	Батлагдсан эсэх	Тийм-1 Үгүй-0	-	1				ОНТ 10000.0	БОАЖГ СДОА	
1.6	Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг 20 га-д хийлгэх.	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ	Га	1	6	11	16	21	Хувийн хэвшил 200000,0	БОАЖГ Сумдын ЗДТГ	
1.7	Мод тарьж ургуулсан сум, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийг шалгаруулж урамшуулах, уралдаан зохион байгуулах.	Зохион байгуулсан уралдааны тоо	тоо	-	2	2	3	4	ОНТ 128000.0	АЗДТГ БОАЖГ СДОАНГ и Сумдын ЗДТГ	
1.8	Дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн усыг хэмнэлттэй, үр ашигтай ашиглах зорилгоор саарал усаар ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг хийх	Жилд ашиглах цэвэршүүлсэн усны хэмжээ	тн	-	-	540000	108000 0	1620000	-	ХТГ “Дундго вь-Ус” ОНӨҮГ	

Дүнгийн Төрөл	Хүндийн төрөл, ажлын төрөлөөр үргэлжлүүлж аажуурч боловч иргэн нүүдэд өөрсө, хариуцаж үйс, хөрөнгийн үндсэн хэсгээр бүрэн ажлын хүндийн үргэлжлүүлж аажуурч боловч 2022 онд ажлын үндсэн ажлын хүндийн үргэлжлүүлж аажуурч боловч 2022 онд ажлын үндсэн ажлын	Хүндийн төрөл аажуурч	Тоо	76	86	97	109	122	УТ, ОНТ, Хувийн хэвшил, Төсөл хөтөлбөр 250000.0	ХОХБТ Х, ХХААГ, тариала н эрхлэгч
	2.1 Сумдад иргэдийн бүлгийг түшиглэн зуны хүлэмжийн аж ахуйг дэмжих, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн өвөл, хаврын улиралд хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах.	Хүлэмжийн тоо	Тоо	76	86	97	109	122	УТ, ОНТ, Хувийн хэвшил, Төсөл хөтөлбөр 250000.0	ХОХБТ Х, ХХААГ, тариала н эрхлэгч
		Талбайн хэмжээ	М ²	10046	11246	12566	14006	15566		
		Ургацын хэмжээ	Тн	40,6	50,6	60,6	70,6	80,6		
	2.2 Хүнсний ногооны технологийн ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үр, бордоо, гар багаж, усалгааны болон хүлэмжийн тоног төхөөрөмж нийлүүлдэг аж ахуйн нэгжтэй тариаланчдыг холбож зуучлах, дэмжих.	ААН, иргэний тоо	тоо	30	50	70	90	110	-	ХОХБТ Х, ХХААГ, тариала н эрхлэгч

2.3	Сайнцагаан суманд байгуулагдсан "Өвлийн нарлаг хүлэмж"-ийг түшиглэн хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулах.	Талбайн хэмжээ	М ²	1200	1200	1520	1520	1520	УТ, ОНТ, Хувийн хэвшил, Төсөл хөтөлбөр 25000.0	ХОХБТ Х, ХХААГ, тариалан эрхлэгч
		Ургацын хэмжээ	Тн	3,8	13,8	23,8	33,8	43,8		
2.4	Нутгийн хөрсөнд тарьсан төмс хүнсний ногоо, жимс жимсгэнийг бизнес эрхлэгчдийг дэмжих төвийн борлуулалтын цэгээр дамжуулан зах зээлд нэвтрүүлэн бүтээгдэхүүнийг нь сурталчлах, нэрийн бүтээгдэхүүн бий болгох.	Тариаланчийн тоо	Тоо	-	10	15	20	25	-	ХОХБТ Х, ХХААГ, тариалан эрхлэгч
		Борлуулсан ургацын хэмжээ	Тн	-	30	40	50	55		
		Таримлын нэр төрөл	Тоо	-	10	12	14	16		
2.5	Бэлчээрт олон наст ургамал цацах, тариалах, өнжөөж сэлгэж нөхөн сэргээх, тарималжуулах.	Талбайн хэмжээ	Га	10,2	12,5	22,5	30	40	Хувийн хэвшил 50000.0	АЗДТГ ХХААГ Сумдын Засаг дарга
		Ургацын хэмжээ	Тн	12,8	20	31	38	50		

3.1	Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хүнсний ногооны үйлдвэрлэл, жимс жимсгэнэ, ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхыг сайжруулах.	Хамрагдсан хүний тоо	Тоо	-	76	170	270	400	ОНТ 80000.0	АЗДТГ ХХААГ СДОА ТББ
3.2	Байгальд ээлтэй цэцэрлэг, сургууль, эко клубын үйл ажиллагааг эрчимжүүлж чуулга уулзалт, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах.	Хамрагдсан хүний тоо	тоо	60	-	160	-	310	ОНТ 10000.0	АЗДТГ БОАЖГ БСУГ СДОА
3.3	Байгаль орчныг хамгаалах, цөлжилтийг сааруулах талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн мэдээллийн сүлжээгээр сурталчилгаа хийх.	Байршуулсан мэдээний тоо	тоо	600	800	1000	1200	1400	ОНТ 10000.0	АЗДТГ ХХААГ БОАЖГ СДОА
		Хандалтын тоо		100000	40000	60000	80000	100000		